



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 1,556.3 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогтод дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-д “Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна” гэсэн заалтыг мөрдөж ажиллан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

2.3.Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулж, хяналт тавьж ажиллах;

2.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” 102 дугаар тогтоолыг мөрдөж, байгууллагын санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлснээс олсон орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлж ажиллах, 2016-2017 онд улсын төсөвт төвлөрүүлээгүй 10.8 сая төгрөгийн түрээсийн орлогыг 2018 оны 2 дугаар улиралд багтаан төсөвт төвлөрүүлэх;

2.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Ногдол ашиг төвлөрүүлэх тухай” 101 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, компанийн 2015 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгийн дүнгээс төсөвт төвлөрүүлээгүй байгаа 501.4 сая төгрөгийг ногдол ашгийг ТӨБЗГ-ын улсын орлогын холбогдох дансанд төвлөрүүлэх;

0001597

2.6. Мөнгөн кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэх явдлыг зогсоох;

2.7. Гадаад, дотоод албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, эрх бүхий байгууллага, удирдах албан тушаалтны удирдамж, шийдвэргүй томиллолтоор ажилладаг явдлыг зогсоох;

2.8. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дэх заалтыг мөрдөж, гэрээгээр худалдаж авахаар тооцсон бараа материал, ажил үйлчилгээний үнийн дүнгээс 10 хувийн татварыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлэх;

2.9. Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-т заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчмыг мөрдөж ажиллах;

2.10. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх;

2.11. Шалгалтын тайланд тусгагдсан, байгууллагын тайлан балансад бүртгэлтэй боловч одоогоор ашиглалтгүй байгаа 84 сая төгрөгийн өртөг бүхий тусгай зориулалтын автомашины талаар санал, боловсруулж ТӨБЗГ-т хүргүүлэх;

2.12. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан ажиллаж, биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд ТӨБЗГ-т ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчин худалдан авалт хийсэн	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	312,497.61	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 33.1, 33.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллах
2	Гэрээ хэлцэлгүй худалдан авсан ажил үйлчилгээ	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	58,426.01	Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
3	Захиалгын хуудасгүй бэлтгэсэн сэлбэг хэрэгслэл, бараа материал	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	349,014.32	Бараа материал бэлтгэх журам боловсруулж, мөрдөж ажиллах
4	Зөвшөөрөлгүй бэлтгэсэн үндсэн хөрөнгө	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	21,564.09	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг мөрдөж ажиллах
5	Үндсэн баримтгүй зарцуулсан хөрөнгө	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	109,069.35	Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
6	Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй үргүй зардал	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	112,202.00	Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийг мөрдөж ажиллах
7	ХХОАТ ногдуулж төлөөгүй	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	33,305.19	Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хуулийг мөрдөж ажиллах
8	Төсөвт төвлөрүүлээгүй ногдол ашиг	Захирал Ч.Баттуяа, Ерөнхий ня-бо Л.Оюунчимэг	501,400.00	ТӨБЗГ-ын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 101 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах
9	Төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	10,800.00	"Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах
10	Гадаад, дотоод албан томилолтын журам зөрчсөн	Захирал Г.Баярцогт, Ерөнхий ня-бо Б.Наранцэцэг	48,019.50	Албан томилолтын журмыг мөрдөж ажиллах
	Дүн		1,556,298.07	
	Зөрчлийн дүн /оноор/	2016	1,426,725.05	
	Зөрчлийн дүн /оноор/	2017	129,573.02	